

АУДИТЫН ГАЗРААС ГҮЙЦЭТГЭЛИЙН БОЛОН НИЙЦЛИЙН АУДИТ ХИЙСЭН ДҮН

УИХ-ын төсвийн байнгын хорооны захиалга, УАГ-ын нэгдсэн удирдамжаар Улсын төсвийн хөрөнгө оруулалтын хэрэгжилт, үр дүн, Монгол Улсын 2014 төсвийн гүйцэтгэл, үндсэн чиглэл, шилэн данс зэрэг 4 гүйцэтгэлийн аудит, Орон нутгийн хөгжлийн санд нийцлийн, өөрийн санаачлагаар Хутаг-Өндөр, Могод, Бугат, Хангал сум, Хялганат тосгон, орон нутгийн хөгжлийн сан зэрэг 5 нийцлийн аудит нийт 10 салбар, байгууллагад гүйцэтгэлийн болон нийцлийн аудит хийлээ.

ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТ ХИЙСЭН ДҮН

Улсын төсвийн хөрөнгө оруулалтын хэрэгжилт, үр дүн:

Аймгийн хэмжээнд Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2014 онд 18279.2 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 18 төсөл арга хэмжээг 10554.2 сая төгрөгөөр санхүүжүүлэхээр Төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулиар батлагдсанаас 6954.9 сая төгрөгийн 12 төсөл арга хэмжээ нь аймгийн засаг даргад эрх шилжиж ирсэн байна.

Хуулиар батлагдсан нийт хөрөнгө оруулалтын 47.4 хувь буюу 5000.0 сая төгрөгийг Барилга хот байгуулалтын, 32.6 хувь буюу 3437.1 сая төгрөгийг боловсрол, соёл шинжлэх ухааны, 12.0 хувь буюу 1262.9 сая төгрөгийг эрүүл мэнд спортын, 4.6 хувь буюу 485.0 сая төгрөгийг эрчим хүчний, 3.5 хувь буюу 369.2 сая төгрөгийг хүнс хөдөө аж ахуйн сайдын багцаас санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Нийт арга хэмжээний 2423.5 сая төгрөг буюу 22.9 хувь нь өмнөх онуудаас хэрэгжиж байгаа, 77.1 хувь нь шинээр хэрэгжүүлэх төсөл арга хэмжээ тусгагджээ.

Нийт хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын арга хэмжээний 10 ажил нь бүрэн хэрэгжсэн, 8 ажил нь хэрэгжих шатандаа явагдаж байна.

Дутуу хэрэгжсэн Тэшиг сумын сургуулийн өргөтгөл, Булган сумын 150 ортой цэцэрлэг, 640 хүүхдийн сургууль, 50 ортой төрөх эмнэлэг, Хутаг-Өндөр сумын эмнэлгийн өргөтгөлийн ажлууд нь он дамжин хэрэгжиж, гүйцэтгэгчийн ажил удаашралтай байснаас хугацаа сунгасан, нэмэлт төсөв шаардлагатай болсон, аймагт эрх нь шилжиж ирээгүй салбарын чиглэлээр орон нутагт хийгдэж байгаа хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний барилгын ажлын гүйцэтгэл хангалтгүй, аймаг орон нутгийн оролцоо, ГХБХБГазар, СТСХэлтсээс хяналт тавих боломжгүй ажлууд байна.

Аймагт хэрэгжиж байгаа хөрөнгө оруулалт нь орон нутгийн хэрэгцээ шаардлагыг тодорхойлж төлөвлөсөн ч батлагдсан хөрөнгө нь техник эдийн засгийн үндэслэлгүй, зураг төсөв байхгүй шинээр зураг төсөв боловсруулахад батлагдсан хөрөнгөнөөс хяналтын төсөв нь илүү гарч нэмэлт эх үүсвэр шаардлагатай болдог, гүйцэтгэгч компаниуд гэрээний үүргээ биелүүлдэггүй, санхүүжилт хугацаандаа олгогдоогүй зэргээс шалтгаалж хөрөнгө оруулалтын ажил удаашралтай, гэрээний хугацаанд дуусаагүй зөрчлүүд байна.

Худалдан авах ажиллагааны архивласан баримт бичигт Үнэлгээний хорооны гишүүнээр ажиллахыг зөвшөөрсөн мэдүүлэг, ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх, зөрчил үүссэн тухай мэдэгдлүүд бүрэн бус, хоосон маягт хавсаргасан, аймгийн Засаг даргын захирамжийн хавсралтаар батлагдсан ажлын нэр захирамжаас

зөрүүтэй, үнэлгээний хорооны хуралдааны тэмдэглэлд ажлын нэр зөрүүтэй зэрэг ажлын хариуцлагатай холбоотой зөрчлүүд илэрлээ.

Зохион байгуулагдсан худалдан авах ажиллагааны үнэлгээний хороонд аймгийн ИТХ-аас томилсон иргэний төлөөллийг оролцуулахаар захирамжаар баталдаг ч 4 ажлын шалгаруулалтанд томилогдсон иргэний төлөөллийг оролцуулаагүй ТБОНӨХБАҮХАТ хуулийн 47.4 дэхь заалтыг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй зөрчил илэрлээ.

Орон нутагт эрх шилжиж ирсэн 12 ажлын сонгон шалгаруулалтыг аймгийн худалдан авах ажиллагааны албанаас зохион байгуулж тендерийн үр дүнгээр 94.8 сая төгрөгийн хэмнэлт гарсан, холбогдох мэргэжлийн байгууллагуудаас хяналт тавьж ажилласнаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний 83.4 хувь буюу 1585.1 сая төгрөгийн 10 ажил гэрээний хугацаанд дуусаж 2 ажлын гэрээ дуусаагүй хэрэгжиж байна. Харин салбар яамдын чиглэлээр 3-4 жил дамжин хэрэгжиж байгаа 5 ажил энэ онд мөн дуусалгүй дараа онд үргэлжлүүлэн хэрэгжихээр болсон байна.

Аудитаар 296.0 сая төгрөгийн зөрчил илрүүлж зөрчлийг арилгуулахаар 2 албан шаардлага, аймгийн ИТХ дарга, аймгийн Засаг дарга, ГХБХБГ-ын дарга, СТСХ-ийн дарга, ХААА-ны дарга нарт 6 хугацаатай зөвлөмж хүргүүлж ажиллаа.

Аймгийн 2014 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл:

Аймгийн ИТХ-ын 2013 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн хуралдааны 05/04 тоот тогтоолоор баталсан аймгийн орлого, санхүүгийн дэмжлэг, орон нутгийн хөгжлийн санд авах орлого, тусгай зориулалтын шилжүүлгийг 2014 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн 08/01 тоот тогтоолоор тодотгол **аймгийн орлогыг** 16708604.3, урд оны үлдэгдлийг 740984.0, улсын төсвөөс авах санхүүгийн дэмжлэгийг 2254747.1, орон нутгийн хөгжлийн санд авах орлогыг 9945295.1, тусгай зориулалтын шилжүүлгийг 23186203.6 нийт эх үүсвэрийг 52890834.1 мянган төгрөгөөр баталснийг 2014 оны 12 дугаар сарын 22-ны өдийн 08/01 тоот тогтоолоор оны эхний үлдэгдлийг 1013563.7, өмчийн татварыг 200.0, төсвийн байгууллагын өөрийн орлогыг 4700.0 мянган төгрөгөөр нэмэгдүүлж, ус ашигласны төлбөрийг 1315312.0 мянган төгрөгөөр бууруулан нийт дүнгээр 136871.7 мянган төгрөгөөр бууруулан **аймгийн орлогыг** 15778035.5, урд оны үлдэгдлийг 175454.7, улсын төсвөөс авах санхүүгийн дэмжлэг, орон нутгийн хөгжлийн санд авах орлогыг 691733.7 мянган төгрөгөөр бууруулан 9253561.4, улсын төсвөөс авах санхүүгийн дэмжлэгийг 2167802.3 мянган төгрөгөөр нэмэгдүүлэн 4422549.1, тусгай зориулалтын шилжүүлгийг 847092.8 мянган төгрөгөөр нэмэгдүүлэн 24033296.4 мянган төгрөг болгон баталсан байна.

Аймгийн орлого тодотгосон дүнгээс 1566891.1 мянган төгрөгөөр тасарснаас авто болон өөрөө явагч хэрэгслийн татвар 55259.7, хүү торгуулийн орлого 31279.9, нэр заагдаагүй орлого, 40697.9 мянган төгрөгөөр тасарч, цалин хөлстүүнтэй адилтгах орлогын албан татвар 218927.7, үл хөдлөх хөрөнгийн албан татвар 33246.7, газрын төлбөр 21107.4 мянган төгрөгөөр давж биелсэн байна.

Сумдын орлого тодотгосон дүнгээс 150176.3 мянган төгрөгөөр тасарснаас хувиараа материал бэлтгэсний орлогын албан татвар 125482.3, улсын тэмдэгтийн хураамж 23601.4, рашаан, ус ашигласны төлбөр 3120.6, хог хаягдлын хураамж 2053.4, ойгоос хэрэглээний мод, түлээ бэлтгэж ашигласны төлбөр 1017.5, ашигт малтмалаас

бусад баялаг ашигласны төлбөр 743.3, түрээсийн орлого 490.7, нэр заагдаагүй орлого 172.4, нэр заагдаагүй орлого 52296.1 мянган төгрөгөөр тус тус тасарсан байна.

Аймгийн нийт санхүүжилтийн эх үүсвэрийг улсын төсвөөс 1761027.5 мянган төгрөгийн санхүүгийн дэмжлэг авч, оны эхний үлдэгдлээс 1714151.5, аймгийн орлогоор 15928970.0, сумдын орон нутгийн орлогоор 1561004.5, аймгийн шууд харъяа төсөвт байгууллагуудын өөрийн орлогоор 108959.6, сумдын төсөвт байгууллагуудын өөрийн орлогоор 76553.5, санхүүгийн дэмжлэгээр аймгийн төсөвт байгууллагуудад 9114849.4, сумдын төсөвт байгууллагуудад 867210.5, оны эхний үлдэгдлээс аймгийн төсөвт байгууллагуудад 2154067.8, сумдын төсөвт байгууллагуудад 387552.8 нийт орлогыг аймгийн төсөвт байгууллагуудад 29067874.3, сумдын төсөвт байгууллагуудад 10697361.4 мянган төгрөгөөр санхүүжүүлсэн байна.

Орон нутгийн орлогыг нийт дүнгээр биелүүлсэн ч орлогыг тодорхойлох боломжгүй иргэний орлогын албан татвар, улсын тэмдэгтийн хураамж, түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны нөөцийн төлбөр, хогны татвар, түрээсийн орлого, хүү торгуулийн орлого зэргийг нэр төрлөөр нь тасалсны дотор Баяннуур сумын нийт орлого 4008.6 мянган төгрөгөөр давж биелсэн ч 10 нэр төрлийн татвараас 9-ийг нь 270.0-1939.8 мянган төгрөгөөр тасалсан, Бугат, Гурванбулаг, Могод, Орхон, Сайхан, Сэлэнгэ, Тэшиг, Хангал, Хишиг-Өндөр, Хутаг-Өндөр сумдууд 3-5 нэр төрлөөр тасалсан байна.

Цаашид сумын татварын орлогын төлөвлөгөөг бүрэн ханган биелүүлэх, төлөвлөсөн нэр төрлийн орлогыг тайлант хугацаанд оруулах, орлого нэмэгдүүлэх нөөц боломжийг бүрэн дайчилж ажиллах сумын санхүүгийн албаны дарга, төрийн сангийн төлөөлөгч, татварын байцаагч нар холбогдох салбар, нэгж хариуцсан албан тушаалтнууд, татвар төлөгч нартай хамтарч ажиллах, орлогын төлөвлөгөө тасарсан шалтгаан, нөхцөл байдлыг судалж аймаг, сум, байгууллагын удирдлагууд тодорхой арга хэмжээ идэвх, санаачлагатай авч ажиллах шаардлагатай байна.

Орон нутгийн байгууллагуудад нийт 26500.9 сая төгрөг зарцуулснаас 30.45 хувь буюу 8069.6 сая төгрөг нь орон нутгийн хөгжлийн санд, 18.79 хувь буюу 4980.0 сая төгрөг нь аймгийн Байагаль хамгаалах санд, 15.40 хувь буюу 4080.4 сая төгрөг нь нийгмийн халамжийн үйлчилгээнд, 14.29 хувь буюу 3785.9 сая төгрөг нь сумдын ЗДТГ-т, 3.20 хувь буюу 848.8 сая төгрөг нь багийн Засаг даргад, 2.85 хувь буюу 754.4 сая төгрөг нь сумдын ИТХ-д, 2.69 хувь буюу Засаг даргын нөөц хөрөнгөнд, 1.53 хувь буюу 405.0 сая төгрөг нь мал эмнэлгийн үйлчилгээнд, 1.33 хувь буюу 352.2 сая төгрөг нь Байгаль орчины газарт, 1.17 хувь буюу 310.8 сая төгрөг нь Хот тохижилтын газарт, 1.12 хувь буюу 296.6 сая төгрөг нь орон нутгийн хөрөнгө оруулалтанд, 3.18 хувь буюу аймгийн ИТХ, ГХУСАЗЗ, авто замын сан, ИОНХА, Нөөцийн газар, ХААА, Өмчийн алба, сум дундын ойн анги, Хүүхдийн зуслан зэрэг байгууллагуудад хуваарилагдан зарцуулагдсан байна.

Аймгийн шууд харъяа байгууллагуудын төсөвт аймгийн ИТХ тодотгол хийгээгүй, анх баталсан дүнгээр санхүүжүүлсэн байхад ИТХ-аас сумдад баталсан төсөвт сумын ИТХ-ууд 2-3 удаа тодотгол хийсэн, аймгийн ИТХ тодотгол хийгээгүй байхад Булган, Гурванбулаг, Тэшиг, Хангал сум 2 удаа, Дашинчилэн, Могод, Орхон, Сэлэнгэ, Рашаант, Хишиг-Өндөр сум, Хялганат тосгон 1 удаа тодотгол хийсэн нь эдгээр сумдын Засаг дарга, ИТХ төсвийн тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 2 дахь “Засаг дарга дараах тохиолдолд тухайн жилийн төсвийн тодотголыг боловсруулж, тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн мэдүүлнэ.” хэсгийн 2 дахь “урьдчилан тооцох боломжгүй нөхцөл байдлын улмаас

төсвийн орлого буурах, зарлага нэмэгдэж, орон нутгийн төсөв алдагдалтай болох нөхцөл байдал бий болсон”, 3 дахь “энэ хуулийн 29.7-д /29.7.Үйлдвэрлэлийн түүхий эдийн үнийн индекс нь батлагдсан төсөвт тооцсон хэмжээнээс хоёр дахин өссөн тохиолдолд түүнийг тухайн жилийн төсвийн тодотголд тусган өөрчилнө./ заасан үндэслэл бий болсон тохиолдолд батлагдсан хөтөлбөр, төсөл, арга хэмжээний төсөвт өртөгт өөрчлөлт оруулах.” гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Тодотгол хийхдээ Баян-Агт сум төсвийг 2446.5 мянган төгрөгөөр бууруулж баталсан байхад бусад сумдууд буюу Булган сум 61311.5, Хангал сум 42987.2, Гурванбулаг сум 21800.0, Могод сум 16589.7, Хишиг-Өндөр сум 14711.4, Орхон сум 14226.2, Сайхан сум 12757.0, Тэшиг сум 6112.3, Сэлэнгэ сум 5339.6, Рашаант сум 5000.0, Хялганат тосгон 4785.2, Хутаг-Өндөр сум 4743.2, Дашинчилэн сум 4720.1, Баяннуур сум 1228.7, Бугат сум 1000.0 мянган төгрөгөөр тус тус нэмэгдүүлж баталсан байна.

Тодотголоор нэмэгдсэн зардлуудын гүйцэтгэлийг судалж үзэхэд Булган, Могод, Сайхан, Сэлэнгэ, Рашаант, Хишиг-Өндөр сумдын тодотгол хийсэн зардлууд харьцангуй хэмнэлттэй зарцуулагдсан, оны эцэс болсон 12 дугаар сарын 20-диор байгууллагын дутагдах болон зайлшгүй шаардлагатай зардлуудыг бодитой тооцох боломжтой үед тодотголыг үндэслэл муутай, оны эцэс болж төрийн сангийн гүйлгээ хаагдах дөхсөн үед буюу цаг хугацааны хувьд боломжгүй үед тодотгол хийж байгаад анхаарч ажиллах шаардлагатай байна.

Сумдын ЗДТГ-ууд нийт зардлаа хэтрүүлээгүй ч сумдаас Баяннуур, Дашинчилэн, Орхон, Рашаант, Хутаг-Өндөр сум, Хялганат тосгоны ЗДТГ-ууд албан томилолтын зардлын 4735.8, түлш халаалтын зардлын 1551.4, тээвэр шатахууны зардлын 974.1, НДШ-ийн 819.3, нэг удаагийн тэтгэмж урамшууллын зардлын 170.0, гэрэл цахилгааны зардлын 49.4, ном хэвлэлийн зардлын 35.9, нормын хувцас зөөлөн эдлэлийн зардлын 22.4 **нийт 14210.6 мянган төгрөгийн хэмнэлт буюу зарцуулагдаагүй үлдэгдлээс** тээвэр шатахуунд 2857.2, бусад зардалд 974.1, шуудан холбоонд 305.4, урсгал засварт 360.0, гэрэл цахилгаанд 253.0, нэг удаагийн тэтгэмж урамшуулалд 200.0, албан томилолтонд 76.8, бичиг хэрэгт 19.5 **нийт 5529.4 мянган төгрөгийг зардлын зүйл анги, бүлэг хооронд,** түүний дотор хамгийн их дүнгээр буюу нийт шилжүүлэн зарцуулсан зардлын 45.06 хувийг Рашаант сум тээвэр шатахуунд 2491.8, 23.14 хувийг Дашинчилэн сум шуудан холбоо, бусад зардалд 1279.5 мянган төгрөгийг шилжүүлэн зарцуулсан байна.

Төлөвлөсөн нийт зардлаас байгаль хамгаалах сан 2339515.7, орон нутгийн хөгжлийн сан 2020041.1, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт 1171923.3, авто замын сан 283559.5 мянган төгрөгөөр дутуу зарцуулагдсан нь байгаль хамгаалах, орон нутгийн хөгжлийн сангийн төсөл арга хэмжээнүүд жил дамнан хэрэгжиж санхүүжигдэхээр байгаа, санхүүжүүлж дуусаагүй өглөгөөр тусгасан, орон нутгийн хөрөнгө оруулалтын дутуу зарцуулалт нь жилийн эцэст тодотголоор нэг төсөл, арга хэмжээ нэмж санхүүжүүлэхээр тусгасан зэрэгтэй холбоотой байна.

Орон нутгийн байгууллагуудын төлөвлөсөн хэтрэлт, хэмнэлтийн шалтгааныг судалж үзэхэд:

- ✓ Гадаад арга хэмжээнд аймгийн ИТХ 15000.0 мянган төгрөг төлөвлөснөөс 6118.4, ЗДТГ 20000.0 мянган төгрөг төлөвлөснөөс 15897.8, Могод сумын ЗДТГ 1000.0 мянган төгрөг төлөвлөснөөс 884.5 мянган төгрөг зарцуулсан нь зардал дутуу

зарцуулагдсан шалтгаан нь Могод сумынх гүйцэтгэлээр гарсан, аймгийн ИТХ, ЗДТГ Засгийн газрын 2014 оны 147 дугаар гарч хэрэгжсэнтэй шууд холбоотой,

- ✓ Цалин, нэмэгдлийн зардал аймгийн хэмжээгээр 134872.7 мянган төгрөгөөр дутуу зарцуулагдсан нь аймгийн хэмжээнд орон нутгийн захиргааны байгууллагуудад 554 хүн ажиллахаар төлөвлөснөөс 551 хүн ажилласнаас аймгийн ИТХ-д 12-10, аймгийн ЗДТГ-т 60-60, 16 сум, 1 тосгоны ИТХ-д дарга, нарийн бичгийн дарга зэрэг нийт 51-53, сум, тосгоны ЗДТГ-т 351-347, сумдын багт 80-81 хүн ажилласан байгаагаас цалингийн зардлын хэмнэлт нь орон тооны хөдөлгөөнөөс шалтгаалаагүй, төсвийн төлөвлөлт, тооцоололтой шууд холбоотой,
- ✓ Төсвийн байгууллагуудын зардлууд нийт дүнгээрээ хэтрээгүй нь Засгийн газрын 2014 оны 147 дугаар тогтоол гарч хэрэгжсэн нь нөлөөлсөн,
- ✓ Байгууллагууд зардал хооронд шижүүлэн зарцуулж байгаа нь төлөвлөлттэй холбоотой байгаагаас гадна Засгийн газрын 2013 оны 03 дугаар сарын 29-ний өдрийн 73 дугаар тушаалар баталсан “Төсвийн захирагчийн төсөвт зохицуулалт хийх журам”-ын 5.1 дэхь “Төсвийн байгууллага энэ журмын 3.1.4-т заасан үндэслэлээр цалин хөлс, нэмэгдэл урамшуулал, нийгмийн даатгалын шитгэлийн зардлын бүлэг болон дангаар хянагдах зардлын бүлэглэлээс бусад зардлын бүлэг хооронд жилийн батлагдсан төсвийн тухайн зардлын бүлгийн дүнг 20 хүртэл хувиар нэмэгдүүлэх зохицуулалтын хүсэлт гаргаж болно.”, 5.3 дахь “Аймаг, нийслэл, сум, дүүргийн төрийн сан нь төсвийн байгууллагаас ирүүлсэн 10 сая төгрөг хүртэлх зохицуулалт хийх хүсэлтийг судлан, зөвшөөрөгдсөн зардлын бүлэг хооронд зохицуулалтыг хийж, бүртгэн баталгаажуулна.” гэсэн заалтыг аймаг, сумын төрийн сангууд хэрэгжүүлэхдээ тавих хяналтыг сулруулдаг, зайлшгүй шаардлагыг нягталж хянаддаггүйтэй холбоотой байна.

Орон нутгийн захиргааны байгууллагын удирдлага, төрийн сангууд, санхүү, бүртгэлийн ажилтнууд төсвийн төлөвлөлтийг оновчтой тооцоогүй, төлөвлөлтийг өмнөх онуудын гүйцэтгэл, тооцоо судалгаанд үндэслээгүй, хөрөнгийг зарцуулахдаа арвилан хэнмнэлттэй, үр нөлөөтэй зарцуулах талаар идэвх санаачлагатай ажиллаагүйгээс зардлыг зүйл анги, бүлэг хооронд шилжүүлж зарцуулсанд дүгнэлт хийн цаашид энэ байдлыг таслан зогсоох арга хэмжээ авч, төсвийн зарцуулалтыг төлөвлөсөн хэмжээнд зарцуулж байгааг хянахаас гадна зардлын эдийн засгийн ангиалал, зүйл ангиар зарцуулж байгаа эсэхэд хяналт тавих, төсвийг үр нөлөөтэй зарцуулах талаар сайн ажиллаж байгаа менежер, бүртгэлийн ажилтныг урамшуулах, хариуцлага алдаж, санхүүгийн алдаа зөрчил гаргаж байгаад нь тухай бүр хариуцлага тооцож ажиллах нь зүйтэй байна.

Орон нутагт хэрэгжүүлж байгаа төсөл сангаар Бугат сумаас бусад нийт 15 сум, 1 тосгоны иргэдэд зээл олгосоноос 2014 оны оны эхэнд 1088 иргэнээс зээл, зээлийн хүүгийн 4666561.4 мянган төгрөгийн авлагатай байснаас тайлант онд нэмж 383 иргэнд 1311426.0 мянган төгрөгийн зээл олгож 1070190.1 мянган төгрөгийн зээл, зээлийн хүүгийн төлбөр төвлөрүүлж оны эцэст 1137 иргэнээс 3661581.1 мянган төгрөгийн авлагын үлдэгдэлтэй байгаагаас

- ✓ Сум хөгжүүлэх сангаас 15 сум иргэдэд зээл олгосоноос 2014 оны оны эхэнд 700 иргэнээс зээл, зээлийн хүүгийн 3162710.2 мянган төгрөгийн авлагатай байснаас тайлант онд нэмж 186 иргэнд 1065400.0 мянган төгрөгийн зээл олгож 877344.4

мянган төгрөгийн зээл, зээлийн хүүгийн төлбөр төвлөрүүлж оны эцэст 742 иргэнээс 3311989.9 мянган төгрөгийн авлагын үлдэгдэлтэй,

- ✓ Баг хөгжүүлэх сангаас 15 сум иргэдэд зээл олгосоноос 2014 оны оны эхэнд 233 иргэнээс зээл, зээлийн хүүгийн 1353334.2 мянган төгрөгийн авлагатай байснаас тайлант онд нэмж 147 иргэнд 132420.0 мянган төгрөгийн зээл олгож 120500.3 мянган төгрөгийн зээл, зээлийн хүүгийн төлбөр төвлөрүүлж оны эцэст 235 иргэнээс 150245.1 мянган төгрөгийн авлагын үлдэгдэлтэй,
- ✓ Жижиг дунд үйлдвэрийг дэмжих сангаас 14 сум, 1 тосгон иргэдэд зээл олгосоноос 2014 оны оны эхэнд 155 иргэнээс зээл, зээлийн хүүгийн 127109.5 мянган төгрөгийн авлагатай байснаас тайлант онд нэмж 44 иргэнд 63930.0 мянган төгрөгийн зээл олгож 71597.4 мянган төгрөгийн зээл, зээлийн хүүгийн төлбөр төвлөрүүлж оны эцэст 153 иргэнээс 124929.3 мянган төгрөгийн авлагын үлдэгдэлтэй,
- ✓ Баян-Агт суманд арилжааны банкинд оны эхэн, эцэст 8788.8 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байгаа бол, Хангал суманд 2014 онд хот бэлчээрийн төслөөр 7 иргэнд 49676.0 мянган төгрөгийн зээлийн үлдэгдэлтэй байна.

Сумдын Төрийн сангийн төлөөлөгч, төсөл сан хариуцсан нь сангийн үйл ажиллагааны нягтлан бодох бүртгэлийг хууль тогтоомжийн дагуу хөтөлсөн, төсөл нь шалгарсан иргэн, аж ахуйн нэгж бүртэй гэрээ байгуулан ажилласан боловч гэрээний биелэлтийг тухай бүр тооцдоггүй, зээлд хамрагдсан төслийн хэрэгжилтийн явц, үр дүнд байнгын хяналт тавьдаггүй, сум бүрийн 7 хүний бүрэлдэхүүнтэй орон тооны бус зөвлөл нь Монгол улсын Засгийн газрын 2011 оны 134 дүгээр тогтоолын 5.3 дахь “Энэхүү журмын 3.1.5-д заасан ажлын хэсэг сум хөгжүүлэх сангийн үйл ажиллагаа, зээлийн гэрээний хэрэгжилтэнд тухайн санхүүгийн жилд 2-оос доошгүй удаа шалгалт хийж, дүнг ИТХ-аар хэлэлцүүлж, сумын нийт иргэдэд мэдээлж байна” гэсэн заалтыг бүрэн хэрэгжүүлж ажилладаггүйгээс эргэн төлөлт хугацаа хэтрэх зөрчил гарсаар байна.

Мөн эргэн төлөлтөөр дансанд орсон үндсэн зээл болон зээлийн хүүгийн орлогын чөлөөт үлдэгдлийг дараагийн төсөлд шуурхай олголгүй удаан хугацаагаар дансанд байршуулдаг, төсөл хэрэгжүүлэгчийнхээ эргэн төлөлт ашиглалт, үйл ажиллагаанд хяналт тавих, зээлийг зорилалт бусаар ашигласан, үйл ажиллагаа нь удааширсан, эргэн төлөлтийн хугацаа хэтэрсэн төсөл хэрэгжүүлэгчдэд хариуцлага тооцох, энэ талаар тодорхой арга хэмжээ авч ажиллаагүй байна.

Цаашид гэрээнд заасан хуваарийн дагуу тухайн жилд төлөх үндсэн зээл, зээлийн хүүгийн тооцоог жилийн дундуур сар, улирал, жилийн дүнгээр бүрэн тооцож бүртгэлд тусгаж байх, хугацаа хэтэрсэн зээлд алданги тооцож, зээлийг төслийн зориулалтын дагуу үр дүнтэй ашиглаж байнгын болон түр ажлын байр бий болгож байгаа эсэхэд хяналт тавин үйл ажиллагааны явцад алдаа, зөрчилд хариуцлага тооцож ажиллах, авлага, өглөгийг данс бүртгэлд бүрэн тусгаж тооцоог бүрэн хийж байх шаардлагатай байна.

Төрийн сангийн авлагаас 1997-2002 онд үүссэн 14 байгууллага, аж ахуйн нэгжтэй холбоотой 45740.3 мянган төгрөгийн авлагаас 1 байгууллагын 1300.0 мянган төгрөг барагдаж оны эцэст 44440.3 мянган төгрөгийн авлага барагдаагүй, 2008 онд үүссэн “Атрын II аян”-ы зээлээс үүссэн 162564.2 мянган төгрөгийн авлагаас 18244.2 мянган төгрөгийн авлага барагдаж 144320.0 мянган төгрөгийн авлага барагдаагүй байна.

Оны эцсийн аймгийн нийт авлагын 4.09 хувь Төрийн сангийн, 6.60 хувь нь орон нутгийн захиргааны болон төсөвт байгууллагуудын, 82.91 хувь нь төсөл сангийн, 1.20 орон нутгийн өмчит үйлдвэрийн газрын авлага эзэлж байна.

Оны эцсийн аймгийн нийт өглөгийн 7.59 хувь Төрийн сангийн, 62.37 хувь нь орон нутгийн захиргааны болон төсөвт байгууллагуудын, 21.51 хувь нь төсөл сангийн, 8.26 хувь нь орон нутгийн өмчит үйлдвэрийн газрын өглөг эзэлж байна.